


“ДЦС-2” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Зорилтот түвшний гүйцэтгэл: /2025 оны хагас жил/

Д/д	Үзүүлэлтүүд		х.н	2024 оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү	
					Төл	Гүйц	Дүн	Хувь
1	Боловсруулсан ЦЭХ		сая.квтц	89.2	85.5	86.0	0.52	101%
2	ДХЦЭХ	Биетээр	сая.квтц	10.3	10.0	9.5	(0.52)	95%
		Хувиар	Хувь	11.5%	11.7%	11.1%	(0.01)	94%
3	Эрчим хүч түгээлт Цахилгаан		сая.квтц	79.0	75.5	76.51	1.04	101%
	Дулаан		мян.Гкал	146.8	133.1	134.0	0.93	101%
4	Нийт орлого		сая.төг	18,593.8	25,020.9	22,939.0	(2,081.86)	92%
	Үүнээс: Цэвэр борлуулалт		сая.төг	18,379.8	24,872.5	22,623.2	(2,249.28)	91%
5	Нийт зардал		сая.төг	19,068.1	25,340.9	22,754.5	(2,586.32)	90%
	Үүнээс: Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	61.8	125.0	46.4	(78.55)	37%
6	Ашиг / алдагдал /		сая.төг	-474.4	-320.0	184.5	504.46	-58%
	Цэвэр ашиг / алдагдал /		сая.төг	-481.9	-320.0	174.6	494.58	-55%
7	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал		төг	1.0	1.0	1.0	(0.02)	98%
8	Авлага		сая.төг	2,533.0	682.5	4,476.2	3,793.67	656%
9	Өглөг		сая.төг	2,024.1	1,475.0	3,920.6	2,445.65	266%
	Үүнээс: Богино хугацаат өглөг		сая.төг	1,689.4	300.0	271.9	(28.14)	91%
10	ХО, ИЗ, ТЗБАХ-ний зардал		сая.төг	525.4	3,313.5	1,246.1	(2,067.36)	38%
11	Жишмэл түлшний зарцуулалт	ЦЭХ	гр/квтц	522.6	553.3	533.1	(20.16)	96%
		ДЭХ	кг/Гкал	193.4	194.4	194.3	(0.10)	100%
12	Нийт ажиллагсдын тоо		тоо	283	328	290	(38.00)	88%
13	Нийт цалингийн сан		сая.төг	6,692.5	9,646.4	7,955.6	(1,690.85)	82%

График 1: 2025 оны хагас жилийн орлого, зардал, ашиг алдагдал

сая.төг




ЦЭХ-ийн гүйцэтгэл /2025 оны хагас жил/

Д/д	Үзүүлэлтүүд		х.н	2024 оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү	
					Төл	Гүйц	Дүн	Хувь
1	Боловсруулсан ЦЭХ		сая.квтц	89.2	85.5	86.0	0.52	101%
2	ДХЦЭХ	Биетээр	сая.квтц	10.3	10.0	9.5	(0.52)	95%
		Хувиар	хувь	11.5%	11.7%	11.1%	(0.01)	94%
3	Цахилгаан эрчим хүч түгээлт		сая.квтц	79.0	75.5	76.51	1.04	101%
	Дулааны эрчим хүчний түгээлт		мян.Гкал	146.8	133.1	134.0	0.93	101%

График 2: Цахилгаан эрчим хүчний түгээлт:


сая.квт.ц



Тайлбар: Тайлангийн хугацаанд 86,022.5 мян квт ц ЦЭХ боловсруулж 76,513.4 мян квт ц ЦЭХ түгээсэн нь төлөвлөгөөнөөс 1,035.9 мян квт ц-аар илүү буюу 101.4 %, ГОТ-оос 43.8 мян квт ц-аар их буюу 100.1 % биелсэн. Урьд оны мөн үетэй харьцуулбал 2,470.9 мян квт ц эрчим хүч бага түгээж 96.9 %-н гүйцэтгэлтэй гарсан. ЦЭХ-ний түгээлтийн бүтцийг харвал: 95.7 % буюу 73,281.3 мян квт ц –ийг ЦДҮС-нд түгээсэн байна. Шиний өөрийн хэрэглэгчдэд 2,793.8 мян квт ц буюу 3.6 %, станцын өөрийн хэрэглээнд 438.3 мян квт ц тус тус түгээсэн байна. “ТТТ” ХХК-н үйл ажиллагаагаа явуулахгүй байгаатай холбоотойгоор шинийн түгээлт өмнөх жилүүдийнхээс бурсан үзүүлэлттэй байна. Дотоод хэрэгцээний ЦЭХ нийт боловсруулалтын 11.05 % байгаа нь төлөвлөгөөнөөс 0.67 %-иар, өмнөх оныхоос 0.4 %-иар тус тус хэмнэсэн байна.

График 3: Дулааны эрчим хүчний түгээлт:

мян.Гкал




Тайлбар: Усаар 11,5660 Гкал, уураар 18,346 Гкал, нийт 134,006 Гкал ДЭХ түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 928 Гкал илүү байна. Диспетчерийн графикийн зөрчилгүй ГОТ 100 % биелсэн. Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 12,797 Гкал дутуу түгээж 91.3 %-н биелэлттэй байна. 2025 оны 05 сарын 26-нд Үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд тодотгол хийгдсэнээр УБДС болон өөрийн түгээлтийн биелэлт 100%, уурын түгээлт 928 Гкал-аар илүү буюу 105.3%-н гүйцэтгэлтэй байна.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт /2025 оны хагас жил/

Д/д	Үзүүлэлтүүд	х.н	2024 оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү	
				Төл	Гүйц	Дүн	Хувь
1	Жишмэл түлшний зарцуулалт ЦЭХ	гр/квтц	522.6	553.3	533.1	(20.16)	96%
	ДЭХ	кг/Гкал	193.4	194.4	194.3	(0.10)	100%

График 4: Жишмэл түлшний хувийн зарцуулалт:



Тайлбар: Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ-д 533.13 гр/квт ц байгаа нь төлөвлөгөөнөөс 20.2 г/квтц-аар бага, өнгөрсөн оны мөн үеэс 10.5 гр/квт ц-аар их, ДЭХ-д 194.25 кг/Гкал байгаа нь төлөвлөгөөнөөс 0.1 кг/Гкал-аар бага, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 0.9 кг/Гкал-аар нэмэгдсэн байна.

Нийт орлого /2025 оны хагас жил/

сая.төг

Д/д	Үзүүлэлтүүд	2024 оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү	
			Төл	Гүйц	Дүн	Хувь
1	ЦЭХ орлого	16,633.5	23,320.1	21,471.2	(1,848.97)	92%
2	ДЭХ орлого	1,746.3	1,552.4	1,152.0	(400.31)	74%
3	Үйл ажиллагааны бус орлого	214.0	148.4	315.8	167.42	213%
4	Нийт орлого	18,593.8	25,020.9	22,939.0	(2,081.86)	92%

График 5: Нийт орлого /2025 оны хагас жил/

сая.төг



Тайлант хугацаанд /2025 он хагас жил/: Цахилгаан эрчим хүчний орлого 21,471.2 сая.төг, Дулааны эрчим хүчний орлого 1,152.0 сая.төг, Үйл ажиллагааны бус орлого 315.8 сая.төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт орлогын дүн 22,939.0 сая.төг байна. Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 53 дугаар тогтоолоор батлагдсан цахилгаан болон дулааны эрчим хүчний тарифтай холбоотойгоор борлуулалтын орлого төлөвлөгөөтэй харьцуулахад 1,081.9 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 94.9 хувийг ЦЭХ-ний, 5.1 хувийг ДЭХ-ний орлого тус тус эзэлж байна. Үйл ажиллагааны бус орлогоор 148.4 сая төг олохоор төлөвлөн 315.8 сая төгрөг олж төлөвлөгөөг 167.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн


Нийт зардал /2025 оны хагас жил/

сая.төг

Д/д	Үзүүлэлтүүд	2024 оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү	
			Төл	Гүйц	Дүн	Хувь
1	Түлшний зардал	7,257.5	8,906.0	9,103.1	197.1	102%
2	Үндсэн ба нэмэгдэл цалин	6,608.3	9,548.2	7,873.7	(1,674.5)	82%
3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	2,240.1	2,199.4	2,056.7	(142.7)	94%
4	Бусад зардал	2,962.2	4,687.3	3,721.0	(966.2)	79%
5	Нийт зардал	19,068.1	25,340.9	22,754.5	(2,586.3)	90%

График 6: Нийт зардал /2025 оны хагас жил/

сая.төг




Тайлант хугацаанд: Үндсэн үйл ажиллагаанд 22,708.1 сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 2,507.8 сая төгрөг хэмнэсэн. Үйл ажиллагааны бус зардал 46.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч төлөвлөснөөс 78.6 сая төгрөг хэмнэсэн байна.

Нийт зардалд түлшний зардал 40.0%, цалингийн зардал 34.6%, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 9.0%, бусад тогтмол зардал 16.4%, үйл ажиллагааны бус зардал 1.1%-ийг тус тус эзэлж байна.

Ашиг, алдагдал /2025 оны хагас жил/ сая.төг

2024 он гүйц		Төл		Гүйц	
Орлого	Зардал	Орлого	Зардал	Орлого	Зардал
18,593.80	19,068.10	25,020.90	25,340.90	22,939.00	22,754.50
-474.30		-320.00		184.50	


График 7: Ашиг, алдагдалын гүйцэтгэл /2025 оны хагас жил/
сая.төг



Авлага /2023 он - 2025 оны хагас жил/

Хугацаа	Дүн /сая.төг/
2023 он	1,280.3
2024 он гүйцэтгэл	1,651.9
2025 он төлөвлөгөө	682.5
2025 оны хагас жилийн гүйцэтгэл	4,476.2

График 8: Нийт авлагын гүйцэтгэл /2021 он - 2024 он/ сая.төг




Тайлант хугацаанд: Нийт авлага хагас жилийн байдлаар 4,476.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд ДҮТ-ийн авлага 3,976.2 сая төгрөг буюу 88.8 хувийг эзэлж байна. Бусад авлага 500 сая төгрөг буюу 11.2 хувь байна.

● **Өглөг** /2023 он - 2025 оны хагас жил/

Хугацаа	Дүн /сая.төг/
2023 он	1,839.1
2024 он гүйцэтгэл	1,276.4
2025 он төлөвлөгөө	1,475.0
2025 оны хагас жилийн гүйцэтгэл	3,920.6

График 9: Нийт өглөгийн гүйцэтгэл /2021 он - 2024 он/

сая.төг



Богино хугацаат өр төлбөр: ДҮТ-ийн авлага өссөнтэй холбоотойгоор БХӨТ өссөн байна. /Богино хугацаат өр төлбөр 3,648.8 сая.төг/

Урт хугацаат өр, төлбөр: "УБДС" ТӨХК-тай хамтран дамжуулан зээлсэн "Эрчим хүчний хэмнэлтийн төсөл" 1492 MON (SF), "Дулааны үр ашгийн төсөл" 1548 MON (SF) -ийн зээлийг батлагдсан эргэх төлөгдөх хуваарийн дагуу төлбөрийн барагдуулж бүртгэсэн. /Урт хугацаат өр төлбөр 271.9 сая.төг/

ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК